


Living the LOTUS

Buddhism in Everyday Life

12
2019

VOL. 171



Үүсгэн байгуулагчийн сургаал

Бурханлаг чанарт мөргөх хоёр үйл

Цагаан Лянхуа Сударт чулуугаар цохисон ч, таягаар жанчуулсан ч нэгэн сэтгэлээр тэр хүнийг хүндлэн мөргөх Насад зэвүүцэхгүй бодисадвагийн мөргөлийн зан үйлийг номлосон байдаг. Мөн түүнчлэн өөртэйгөө сөргөлдөх хүнийг ч гэсэн багшаа хэмээн хүндлэн мөргөх “Дэвадатта бол сайн найз” гэсэн мөргөлийн зан үйлийн талаар айлддаг.

Энэ хоёр бурханлаг чанарт мөргөх үйлийг үргэлж санаж явдаг хүн жинхэнэ сүсэгтэн гэж би боддог.

“Ингэмээр байна”, “тэгмээр байна” хэмээн өөртөө ашигтай зүйлийг л хүсээд байх юм бол харин ч их санасан газар есөн шөнө хоосон хонохын үлгэрээр тэр бүгд нь бүтэлгүйтэж,

үргэлж муухай царайлж байдаг болчихдог. Болсон, болоогүй бүх зүйлд санаа зовоод байх юм бол яг л тийм үр дүн гардаг.

Тиймээс ямар ч зүйл, ямар ч хүнтэй учирсан “Энэ бол надад таарсан бурханы үйл юм байна” гээд бодчих хэрэгтэй.

Тэгээд бодчихоор өөрийнхөө үнэлэмжээр сайн муу, дуртай, дургүй гэж сонголт хийх биш, ямар ч зүйл дээр нөгөө хүндээ тааруулан бодож чаддаг болно. Улмаар ямар ч зүйлийг нүүр тулан хүлээн авч, бүхий л чадлаараа хичээн зүтгэвэл болох юм байна гэсэн сэтгэлтэй болж ирдэг.

Үүсгэн байгуулагчийн сургаал 9, Х.194-195

Living the Lotus
Vol. 171 (2019.12)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Саитоо Кооичироо

Орчуулсан: Ж.Сэлэнгэ

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Турван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд,

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаагай гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Уран яруу өгүүлэх

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Үгийн хүч

Библи судрын “Иоханы захидал” “Хамгийн эхлээд үг байсан.” гэсэн алдартай ишлэлээр эхэлдэг. Үнэхээр л үгийг хэрэглэснээр хүн төрөлхтөн бидний зүрх сэтгэл өсч хөгжиж ирсэн гэж хэлж болно.

Өөрөөр хэлбэл хүний төрөлхийн сэтгэл зүрх буюу “Хүн” гэдэг бодгалийн эгэл жирийн сэтгэл хөдлөл хийгээд бодол санаагаа үг ашиглаж эргэн тойрныхоо хүмүүст дамжуулан, дахин давтан харилцах явцад “хүнлэг сэтгэл” торнин бий болсон гэсэн үг.

Үгийн хүч тийм агуу бөгөөд нөгөөтэйгүүр яруу найрагч Тэра-Яма Шүүжи “Орчин цагийн хүмүүст дутагдаж байгаа зүйл бол «Харилцан ярилцах» гэх зэрэг зүйл бус харин ч «Харилцан дуугүй байх» юм” хэмээн онцолсон байдаг. Үгийн хөгжлийг сэтгэлийн хөгжил гүйцэхгүй байна уу, эсвэл сэтгэлийн хөгжил дордоод байна уу, үгийг нэгнийгээ шархлуулах хэрэгсэл болгох нь ч их байна. Үгийн хүч их байх тусам ихийг ярихаас илүүтэй яг одоо бол чимээгүй сууж, өөрийгөө дүгнэж цэгнэх нь чухал ч байж магадгүй.

Тэгвэл хүмүүстэй илүү сайн харилцаа тогтоохын тулд бид юуг хэрхэн ярьж, дамжуулах хэрэгтэй юм бол?

Пүрүнагаас суралцах нь

Цагаан Лянхуа Сударын “Таван зуун шавийн эш авсаныг өгүүлэх бүлэг”-т Шагжамүни бурхан ном номлохдоо нэгдүгээрт ордог Пүрүнад хандан “Сайтар үг хэл уран яруу өгүүлэн чадах нь түүнээс өөр үгүй болой.” (Пүрүнагаас илүү үгийн хүчийг тултал нь хэрэглэж, илэрхийлж чадах нь үгүй) хэмээн магтсан нэг мөр байдаг. “Энэ хүн аз жаргалтай болоосой” гэсэн чин сэтгэлээр сургаал дамжуулж байсан Пүрүнагийн үгхүмүүсийн зүрх сэтгэлд асар хүчтэй хүрдэг байсан болов уу.





Тэрээр хэрхэн сургаал дамжуулдаг байсныг харвал, сударт өгүүлснээр бол “Хүмүүсийн зүрх сэтгэлд баяр баяслыг өгөх”, “Харилцаж буй хүн нэг бүрийг сайтар ойлгох”, “Чухал зүйлийг хэнд ч ойлгомжтойгоор ярих” гэх мэт дуурайж боломгүй зүйл бол биш байсан бололтой.

“Сайтар үг хэл уран яруу өгүүлэх” гэдэг нь мэдлэг, авьяасаараа тэргүүлэгч нэгний босоо самбарын өмнө урстал ярихыг хэлээгүй гэж бодож байна.

Түүнээс чухал зүйл бол харилцаж буй хүний царай өөрийн эрхгүй тайвширах мэт зөөлөн дулаанаар, сэтгэл гарган ярилцах юм. Ингэснээр хэлж ярих үг аяндаа эелдэг, хүлээж авахад амар болж, хүмүүсийн зүрх сэтгэлд хүрнэ. Нөгөө хүнээ гэсэн сэтгэл л байх юм бол тэр хүний сэтгэл санаагаар зогсохгүй аж амьдралд нь хүртэл санаа тавина гэсэн үг. Тийм үед хэлэх үг Пүрүнагаас дутахааргүй хүчтэй байна гэж бодож байна.

Гагцхүү бидний хувьд шалгуур өндөр нь “Чухал зүйлийг хэнд ч ойлгогдохоор” дамжуулах гэдэг хэсэг юм.

Зохиолч Иноүэ Хисаши гуай үгийн хэрэглэгдэхүүний талаар хэлэхдээ “Хэцүү зүйлийг ойлгомжтой, ойлгомжтой зүйлийг гүнзгийрүүлэн ярих” гэсэн байдаг. Тэгэхээр Шагжамүни бурханы үеэс өнөөг хүртэл хүнд аливаа зүйлийг дамжуулахын үндэс суурь өөрчлөгдөөд байдаг зүйл биш ч байж болох юм.

Хэдий үүнийг ойлгож байгаа ч гэсэн бурханы сургаалыг дэлгэрүүлэхэд “Чухал зүйлийг хэнд ч ойлгогдохоор эелдгээр” ярих нь яах аргагүй хэцүү санагдаж байна.

Энэ тал дээр зохион бичлэг бичих аргын тухай өгүүлсэн Ино-Үэ гуайн хэлсэн “Энгийнээр, ойлгоход хялбараар”, “Зөвхөн та л бичиж чадах тэр зүйлийг өөрийн үгээр бичих” гэсэн хоёр зүйл хэрэг болно.

Бид өөрсдийнхөө үзэж туулсан туршлагаа өөрийн үгээр ярих боломжтой. Мэдэрсэн сэтгэл хөдлөл, анзаарсан зүйлээ байгаагаар нь ярьж чадна. Төгс хүн гэж үгүй болохоор сургаалын юу гэсэн утгатайг ойлгоогүй байлаа ч гэсэн, ойлгоогүй тэр хэвээрээ “Талархмаар”, “Баяртай байна” гэсэн сэтгэлээр, өөрийнхөө ойлгосноор ярих нь “Чухал зүйлийг хэнд ч гэсэн ойлгогдохоор” дамжуулах явдал билээ.

Энэ жил та ямар баяр хөөрийг мэдэрсэн бэ? Тэгээд ямар “сайхан зүйл”-ийг бусдад түгээн дамжуулах гэж байна?

«Косей»2019 оны 12 дугаар сарын дугаар



Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

Оройн Дээд Цагаан Лянхуа Судар Дэвадаттагийн тухай өгүүлэх 12 дугаар бүлэг

Өмнөх “Эрдэнэсийн суварга үзүүлсэнийг өгүүлэх 11 дүгээр бүлэг”-т “Хүний мөн чанар бол бурханлаг чанар” хэмээх агуу үнэн тодорхой болсон. Тэгэхээр “өөрийн мөн чанар бол бурханлаг чанар” гэдгийг ухаарч гэгээрэх нь жинхэнэ хүн болж төгөлдөржихийн нэгдүгээр зам буюу хамгийн дээдийн зам мөр болно гэсэн үг. Энэ нь туйлын үнэн бөгөөд тэрхүү гэгээрлийн оргилд хүрсэн хүн бол өөрөөр хэлбэл Бурхан юм.

Тиймээс ямар ч хүн байсан, жишээ нь нийгэмд ад үзэгдэх муу хүн, хангалттай боловсрол эзэмшээгүй бага насны хүүхэд байсан ч гэсэн бурханлаг чанараа бүрэн мэдэрч, бататгаж чадах юм бол үнэхээр л бурханы гэгээрэлд хүрч чадна. Бурханлаг чанараа мэдрэх сургаалыг энэ хүртэл нарийн тайлбарласан бүлэг бол энэхүү “Дэвадаттагийн тухай өгүүлэх бүлэг” юм. Энэ бүлэг хоёр том хэсгээс бүтсэн. Эхний хэсэгт “Нүгэлт хүн бурханы гэгээрэлд хүрэх тухай”, дараагийн хэсэгт “Эмэгтэй хүн бурханы гэгээрэлд хүрэх тухай” номлосон байдаг.

Нүгэлт хүн бурханы гэгээрэлд хүрэх тухай

Эхлээд Шагжамүни бурхан өөрийн урьд насны амьдралыг ярьдаг. Урьд насандаа Шагжамүни бурхан удаан хугацаагаар улсын хаан байсан ба тэрхүү ая тухтай амьдралдаа сэтгэл ханалгүй, жинхэнэ үнэний сургаалыг (Дармагийн хууль) эрж хайсаар байжээ. Тэгээд тэрхүү сургаалыг олж авахын тулд амьдралаа тэр чигээр нь золиослосон ч хамаагүй хэмээн бодож байв. Улмаар “Ертөнцийн бүх хүнийг аврах сургаалыг айлдах хүн байвал, би насан туршдаа тэр хүний төлөө үйлчлэн, асарч тойглох болно.” хэмээн улс даяараа зарлан түгээсэн байна.

Хэсэг хугацааны дараа нэгэн бадарчин хүрч ирээд, “Би ертөнцийн бүх хүнийг аврах Цагаан Лянхуа хэмээх судрын сургаалыг мэднэ. Хэрэв хаантан та айлдсаныхаа дагуу бүхнийг хийнэ гэвэл би заавал айлдаж өгөх болой.” гэжээ.

Хаан шууд тэр бадарчинд үйлчилж эхлэв. Модны үр түүж, усанд явах зэргээр амьдралынх нь түмэн зүйлийг хийхээр барахгүй газар хэвтэж багш бадарчны суудал нь хүртэл болж өгөв. Тэгэж их хичээн зүтгэхийнхээ хажуугаар тэрхүү туйлын эрхэм дээд сургаалыг сонсож чаджээ. Шагжамүни бурхан ингэж яриад, “Би бурханы гэгээрлийг олоход урьд насны минь тэр үйл маш их нөлөөлсөн ба үнэндээ тэр бадарчин бол Дэвадаттагийн өмнөх төрөл байсан юм. Өөрөөр хэлбэл би Дэвадатта хэмээх дотны нөхөртэй байсны ачаар ийнхүү бурханы гэгээрэлд хүрч, хотол олныг аварч чадсан.” гэжээ. Түүгээр ч үл барам “Дэвадатта бол





цаашид урт удаан хугацааны турш бурханы үйл хийснээр гарцаагүй бурханы гэгээрэлд хүрэх болой.” хэмээн бурхан болох баталгаа хүртэл өгсөн байна.

Дэвадатта бол Шагжамүни бурханы үеэл бөгөөд шавийн тоонд нь багтдаг байсан. Гэвч тэрээр ухаантай боловч сэтгэл нь ухвар мөчид байсан тул Шагжамүни бурхантай сөргөлдөх болж, шашны бүлгэмийнхээ эв найрамдлыг нураан, бүр Шагжамүни бурханы амийг хүртэл хороохыг завдсан муу хүн байжээ. Тийм их ноцтой хэрэг үйлдсэн хүнийг сайн найзаа гэж бодох эсвэл тэрний ачаар бурханы гэгээрлийг олсон, түүнийг гарцаагүй бурханы гэгээрлийг олно гээд байхаар шавь нар нь машид гайхаж, хачирхалтай санагдсан байна.

Ямар ч үед талархсан сэтгэлтэй байх

Шагжамүни Бурхан яагаад урьд насныхаа амьдралыг яриад “Дэвадатта сайн найзынхаа ачаар гэгээрлийг олсон” гэж хэлсэн юм бол. Тэрээр үүгээр цэвэр ариун сэтгэлийн эзэн болох аваас сайн ч бай, муу ч бай бүх зүйл гэрээрэлд хүргэх нөхцөл болдог гэдгийг сургажээ Ийнхүү ухаарах аваас тэнгэр газрын хамаг амьтан, эргэн тойронд болж буй бүх зүйл гэгээрэлд хүрэхэд минь тус болдог хэмээн өөрийн эрхгүй талархах сэтгэлтэй болно.

Энэхүү “Сайн явдал ч, саар явдал ч бүгд гэгээрлийг гүнзгийрүүлэх нөхцөл болдог хэмээн хүлээн авч, түүнд талархах.” гэсэн сэтгэлийг бид сайтар сурах шаардлагатай. Энэ бол тус бүлгийн эхний хагасын хамгийн гол утга санаа юм.

Мөн яагаад Дэвадатта шиг муу хүнд хүртэл бурхан болох баталгааг олгов? Хэдий Дэвадаттагийн энэ насандаа хийсэн муу үйл Шагжамүни бурханыг гэгээрэлд хүргэх нөхцөл болсон гэж хэлж байгаа ч гэсэн үнэндээ Дэвадаттагийн гавьяа зүтгэл гээд байх юм байхгүй. Дэвадаттагийн “муу үйл” бурхан болох баталгаа авснаар цайрна гэсэн үг биш. Тиймээс Дэвадаттад үзүүлэх ”талархал” ба ”бурхан

болох баталгаа” хоёрын хооронд ямар нэг уялдаа холбоо байхгүй.

Шагжамүни бурхан эртнээс дахин давтан айлдсаар ирсэн “Бүх хүн эрх тэгш бурханлаг чанартай” гэсэн жинхэнэ үнэнийг хүмүүсийн зүрхэнд хүчтэй хоногшуулахын тулд хүмүүс уулга алдан гайхахаар гүн гүнзгий хэлбэрийг сонгон гэнэт Дэвадаттагаар жишээ татсан.

Энэ нь чухамдаа олон түмэнд бурханлаг чанарыг нь мэдрүүлэх Шагжамүни бурханы хурц уран ухаан байсан юм.



Нивано Никкёо “Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар /шинэ хэвлэл/”, Косей хэвлэлийн компани, 2016, X. 121-126

Талархал ба баяр хөөрөө олон хүнд дамжуулъя!!!

12 сар дөхөж, удахгүй 2019 он улиран өнгөрөх гэж байна. Та бүхний хувьд энэ жил ямар жил байсан бэ?

Энэ жилийг эргэн харвал “Америкт сургаал дэлгэрсний 60 жилийн ойн санга нарын цуглаан” зохион байгуулагдаж, Хавай, Лос-Анжелас, Сан-Франциско салбарууд ойн баяраа тэмдэглэсэн. Бурхан залах ёслол, Номын багшийн цол авах ёслолоор дамжуулж олон бодисадва нар төрсөн. Мөн энэ сард Бангкок анх удаа Номын багшийн цол авах ёслол болох гэж байна. Өмнөд болон Зүүн Азийн хувьд лидерийн сургалт, залуучуудын сургалт болсон. Дэлхийн бүх салбаруудад Цагаан Лянхуа Сударын сургалт, семинар эрчимтэй зохион байгуулагдсан. Америкын япон лидерүүдийн сургалтаар дамжуулж гишүүн бүр сургаалтай учирсан баяр хөөрөө дахин мэдэрсэн.


Та бүхний хувьд ч гэсэн тоолж баршгүй их талархал, баяр хөөрийг мэдэрсэн жил байсан болов уу. Ийнхүү хүн бүхэн энэ жил хүртсэн ач буян, бурханы зам мөрөө эргэн харж, тэр баяр хөөрөө аль болох олон хүнд дамжуулцгаая.

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Саитоо Кооичи





Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai International

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
 Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224
 E-mail: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
 Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
 E-mail: info@rkhawaii.org Website: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.
 Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, U.S.A.
 Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

Location: 2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
 Mailing Address: POBox 33636, CA 90033, U.S.A.
 Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
 E-mail: rk-la@sbcglobal.net Website: <http://www.rkina.org/losangeles.html>

(Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles)

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado

Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

Location: 1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
 Mailing Address: POBox 778, Pacifica, CA 94044, U.S.A.
 Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437
 E-mail: info@rksf.org Website: <http://www.rksf.org>

(Please contact Rissho Kosei-kai of San Francisco)

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.
 Tel: 1-212-867-5677
 E-mail: rkny39@gmail.com Website: <http://rk-ny.org/>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.
 Tel: 1-773-842-5654

E-mail: murakami4838@aol.com Website: <http://rkchi.org/>

Rissho Kosei-kai of Fort Myers

Website: <http://www.rkftmyersbuddhism.org/>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

Location: 2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.
 Mailing Address: POBox 57138, Oklahoma City, OK 73157, U.S.A.
 Tel: 1-405-943-5030 Fax: 1-405-943-5303
 E-mail: rkokdc@gmail.com
 Website: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809, Denver, CO 80204, U.S.A.
 Tel: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 King Drive, Dayton, OH 45419, U.S.A.
 Website: <http://www.rkina-dayton.com/>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First Street, Suite #1, Los Angeles, CA 90033, U.S.A.
 Tel: 1-323-262-4430 Fax: 1-323-262-4437
 E-mail: info@rkina.org Website: <http://www.rkina.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

Location: 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
 Mailing Address: POBox 692042, San Antonio, TX 78269, U.S.A.
 Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
 E-mail: dharmasanantonio@gmail.com
 Website: <http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003 U.S.A.
 Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
 e-mail: rkseattlewashington@gmail.com
 Website: <http://buddhistlearningcenter.org/>

(Please contact RKINA)

Rissho Kosei-kai of Vancouver

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
 CEP 04116-060, Brasil
 Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377
 E-mail: risho@terra.com.br Website: <http://www.rkk.org.br>
 Instagram: <https://www.instagram.com/rkkbrasil/>
 Facebook: <https://www.facebook.com/rishokosseikaidobrasil>

Risho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000 Brasil
Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377
E-mail: risho@terra.com.br

Korean Rissho Kosei-kai

〒04420大韓民國SEOUL特別市龍山區漢南大路8路6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420,
Republic of Korea
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
E-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Busan

〒48460大韓民國釜山廣域市南區水營路174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

Rissho Kosei-kai of Taipei

台灣台北市中正區衡陽路10號富群資訊大廈4樓
4F, No. 10 Hengyang Road, Jhongjheng District,
Taipei City, 100, Taiwan
Tel: 886-2-2381-1632 / 886-2-2381-1633 Fax: 886-2-2331-3433
Website: <http://kosei-kai.blogspot.com/>

Rissho Kosei-kai of Tainan

台灣台灣台南市崇明23街45號
No. 45, Chongming 23rd Street, East District,
Tainan City, 701, Taiwan
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488
E-mail: koseikaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang,
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8216 Fax: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur,
Gaya-823001, Bihar, India

Rissho Kosei-kai of Patna

Please contact Rissho Kosei-kai of Kolkata

Rissho Kosei-kai of Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Phnom Penh

W.C.73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke,
Khan Reouseykeo, Phnom Penh, Cambodia

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang,
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang,
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
E-mail: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dhamma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka

Tel: 94-11-2982406 Fax: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Please contact Rissho Kosei Dhamma Foundation

Rissho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-626575

Rissho Kosei-kai Chittagong North**Mayani Hoza**

Mayani Barua Para, Mirshari, Chittagong, Bangladesh

Domdama Hoza

Domdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chittagong South**Patiya Hoza**

China Clinic, Patiya, Sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Satbaria Hoza

Village: Satbaria Barua Pra, Chandanish, Chittagong, Bangladesh

Chendirpuni Hoza

Village: Chendirpuni, P.O.: Adhunagor, P.S.: Lohagara,
Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka

408/8 DOSH, Road No. 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh
Tel & Fax: 880-2-8413855

Rissho Kosei-kai Laksham

Village: Dupchar, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmese Market, Tekpara, Sader, Cox's Bazar, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar, Ramu Shibu

Please contact Rissho Kosei-kai of Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar, Raozan Shibu

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Branches under the Headquarters**Buddiyskiy khram "Lotos"**

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk, 693005, Russian Federation

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point,
Hong Kong, People's Republic of China

Rissho Kosei-kai Friends in Shanghai

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

Location: 15F Express Tower, Peace Avenue, Khoroo-1, Chingeltei
District, Ulaanbaatar 15160, Mongolia
Mailing Address: POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia
Tel: 976-70006960 E-mail: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet

2f Ikh Mandal building, Khurenbulag bag, Bayan-Undur sum, Orkhon
province, Mongolia

Branches under the Headquarters**Rissho Kosei-kai di Roma**

Via Torino, 29-00184 Roma, Italia

Tel & Fax: 39-06-48913949 E-mail: roma@rk-euro.org

(Please contact Rissho Kosei-kai di Roma)

Rissho Kosei-kai of the UK**Rissho Kosei-kai of Venezia****Rissho Kosei-kai of Paris****International Buddhist Congregation (IBC)**

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
Tel: 81-3-5341-1230 Fax: 81-3-5341-1224